


ЖИЛИЙН ЭЦСИЙН МАЛ, ХАШАА, ХУДГИЙН ТООЛЛОГЫН ДҮНГИЙН ТУХАЙ

2024 оны 12 дугаар сарын 24

Хориулт


Жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг улсын хэмжээний компанит ажил жилийн өрх, хүн ам, эцсийн мал, хашаа худгийн тооллогын ажлыг сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/143 дугаар бүхий Захирамжийн дагуу сумын 6 багт 8 чиглэл болон ажиллаж, сум орон нутгийн мэдээллийг иргэдэд хүргэн, иргэдийн санал хүсэлтийг сонсон харилцан мэдээлэл солилцож, эрүүл мэндийн үзлэг хийж, шаардлагатай эм тариагаар үйлчилэн ажиллалаа.



Дээрх ажилд Тамгын газрын албан хаагчид, багийн Засаг дарга нар, Багийн хүний эмч болон төрийн байгууллагуудын албан хаагчид, Хурлын төлөөлөгчид зэрэг 39 хүний бүрэлдэхүүнтэйгээр, 8 машин, 2.039.200 (хоёр сая гучин есөн мянга хоёр зуун) төгрөгний 710 литр шатахуун зарцуулсан байна. Луугар 1 дүгээр багт Засаг даргын орлогч Д.Ганболд, Гурван гол 2 дугаар багт Хөдөө аж ахуйн тасгийн дарга Л.Ганзориг, Алтай 3 дугаар багт Нийгмийн даатгалын байцаагч

Т.Өнөржаргал, Цэлгэр 4 дүгээр багт Улсын бүртгэгч Д.Мягмар, Буянт 5 дугаар багт Мал эмнэлгийн тасгийн дарга Б.Нарангэрэл, Хориулт 6 дугаар багт Байгаль орчны мэргэжилтэн Ж.Баттунгалаг нар тооллогын комиссын даргаар ажиллалаа. Тооллогын комиссууд сумын бүх өрхөөр орж, малыг нүд үзэж тоолсон бөгөөд чиглэл тус бүртээ 150-200 км, нийт дүнгээр 1500 орчим зам явж, ажлаа гүйцэтгэсэн байна. Тооллын комиссын ахлагч нарын өгсөн мэдээгээр ажил гүйцэтгэх хугацаанд ямар нэгэн хүндрэл, саад бэрхшээл гараагүй, Луугар 1 дүгээр багийн Хүрэмний урд чиглэл, Цэлгэр 4 дүгээр багийн урд бэл орчим, Алтай 3 дугаар багийн нурууны орчимд бага зэргийн цастай нутгийн бусад хэсэгтээ цасгүй өвөлжилтийн байдал хэвийн, малчид болон өрхүүд өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангасан. Хашаа хороогоо дулаалж, худаг усаа засварлан, түлээ түлш, өөрсдийн дулаан хувцас, эм тариа зэргийг бэлтгэн авсан гэсэн мэдээллийг өгч байна.






Энэ жилийн тооллогын дүнгээр сумын хэмжээнд өрх-916, хүн ам-3009, мал-220869 толгой тоологдсон байна. Өмнөх онтой харьцуулахад 8177 толгой малаар өссөн байна. Одоогийн байдлаар өрх, хүн ам, эцсийн мал, хашаа худгийн тооллогын ажлыг мал тооллогын нэгдсэн программд шивж оруулсан. Бусад мэдээ судалгааг багийн Засаг дарга нар гаргаж байна. Багуудаас авах мэдээ, судалгааг холбоо бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгч, тойрох хуудсаар гарын үсэг зуруулан хүлээлгэн өгч байна. Тооллогын комиссын ахлагч нараас ажил гүйцэтгэсэн тухай илтгэх хуудасыг хүлээн авлаа.

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА  Д. ГАНАА

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:

ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН

МЭРГЭЖИЛТЭН 

Г. ТҮМЭНДЭМБЭРЭЛ



БОГД СУМЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МАЛ ТООЛЛОГЫН ДҮНГИЙН НЭГТГЭЛ

2024 оны 12 дугаар сарын 23

Хориулт

Баг	Бүх мал	Үүнээс				Малын тоогоороо багтаа тэргүүлсэн өрх	
		Т	А	Ү	Х	Я	
1-р баг	35 677	631	1 412	1 095	9 541	22 998	1210
2-р баг	51 115	1 519	813	2 509	10 344	35 930	2031
3-р баг	52 022	249	1 933	2 038	7 636	40 166	1409
4-р баг	31 179	276	613	826	3 862	25 602	1292
5-р баг	38 776	1 707	819	527	4 536	31 187	1111
6-р баг	12 100	87	603	774	2 230	8 406	1001
Сум	220 869	4 469	6 193	7 769	38 149	164 289	
еселт бууралт	8177	595	511	912	3454	2705	
Мал	212692	3874	5682	6857	34695	161584	

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА
НЭГТЛЭЛ ГАРГАСАН:
ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН:



Л.ГАНАА

Г.ТҮМЭНДЭМБЭРЭЛ

БОГД СУМЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН МАЛ ТООЛЛОГЫН ДҮНГИЙН НЭГТГЭЛ

2024 оны 12 дугаар сарын 23

Баг	Бүгд		Мал бүхий өрх		Малчин		Малч-дын тоо	Хориулт
	өрх	хүн ам	өрх	ам бүлийн тоо	өрх	ам бүлийн тоо		
1-р	116	375	14	289	83	289	139	
2-р	171	527	20	441	136	441	214	
3-р	199	648	0	623	180	623	303	
4-р	105	385	4	319	87	319	158	
5-р	150	545	2	462	122	462	211	
6-р	175	529	28	147	38	147	56	
Суурин хүн ам өрхийн тоо	916	3009	68	2281	646	2281	1081	



ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА
 НЭГТЛЭЛ ГАРГАСАН:
 ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ГАНАА
 Г.ТҮМЭНДЭМБЭРЭЛ